



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/472

Булган сум

Г 1000 ширхэг хүлэмжийг сумдад хуваарилах  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/202 дугаар “Гэрээ байгуулах эрх олгох тухай” тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөө аж ахуйн салбар болон Хүлэмж-Хүнс төслөөс нийлүүлсэн 1000 ширхэг хүлэмжийг сумдад хуваарилах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Жаргалсайхан (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд: Д.Ариунжаргал (Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Бодлогын хэрэгжилт, хууль эрх зүйн хэлтсийн дарга)

Г.Давааням (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Б.Одхүү (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Т.Баттулга (Орон нутгийн өмчийн газрын дарга)

Б.Одхүү (“Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ОНӨХХК-ийн захирал)

Нарийн бичгийн дарга: Ч.Амгалан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

2. Дээрх хүлэмжийг аймгийн бодлого чиглэлтэй уялдуулан хуваарилахыг ажлын хэсэг (Д.Жаргалсайхан)-т, хуваарилагдсан хүлэмжийг иргэдэд тараах ажил зохион байгуулахыг сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Төсвийн хөрөнгийг эргэн төлөх нөхцөлтэйгөөр иргэдэд олгож, гэрээ байгуулан, төсвийг төвлөрүүлж ажиллахыг “Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ОНӨХХК (Б.Одхүү)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Sugar Ажил 2024 өдөр бүр Doc/2024/3Захирамж

6324010610